



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 167

Улаанбаатар хот

“Мэдээлэл, холбооны сүлжээ” төрийн өмчит
хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2023 оны эдийн
засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Онцгой
нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний
биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мэдээлэл, холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Гүйцэтгэх захирал Б.Мөнхбаттай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2. “Мэдээлэл, холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирал Б.Мөнхбаттай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж болгосугай.

3. “Мэдээлэл, холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлж, 2023 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт “Сайн” гэж дүгнэгдсэн тул гүйцэтгэх захирал Б.Мөнхбатад хавсралтад заасны дагуу урамшуулал олгосугай.

4. Б.Мөнхбатад олгох урамшууллыг холбогдох зардлаас гаргахыг “Мэдээлэл, холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Санхүүгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч М.Баярсайханд зөвшөөрсүгэй.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132061304

11-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн
167 дугаар тогтоолын хавсралт

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн
167 дугаар тогтоолын хавсралт

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн
167 дугаар тогтоолын хавсралт

"МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ЗАХИРАЛД
2023 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР ОЛГОХ УРАМШУУЛАЛ

д/д	Хуулийн этгээдийн нэр	Захирлын нэр	Цэвэр ашиг	Цэвэр ашгийн дүнгээс хасаж тооцох валютын ханшийн өөрчлөлтөөс олсон ашиг алдагдал	Урамшуулал тооцох цэвэр ашиг	Олгох урамшууллын хэмжээ
1	"Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХХК	Б.Мөнхбат	1,233,260,200.00	1,119,700.00	1,232,140,440.00	25,246,428.00 (хорин таван сая, хоёр зуун дөчин зургаан мянга, дөрвөн зуун хорин найман төгрөг)